



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 21 өдөр

Дугаар 463

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.12, 27 дугаар зүйлийн 27.5.19, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын "Судалгааны ажил зохион байгуулах тухай" 2022 оны 87 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн тахилгат Алтан Хөхий уулын тэнгэрийг тайх тахилгын уламжлал, шинэчлэл, зан үйл болон байгаль, газар зүйн онцлогийг судлах, уулын тэнгэрийг тайх тахилгын ёслолын дэг, ёслол үйлдэх хуваарийг шинэчлэх талаар судалгаа шинжилгээний ажил хийх, уг судалгааны ажлын чиглэлээр эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. "Төрийн тахилгат Алтан Хөхий уулын тэнгэрийг тайх тахилгын зан үйл, байгаль, газар зүйн онцлог, тайлга тахилгын ёслол" эрдэм шинжилгээний бага хурлыг 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр Мянгад сумын төвд зохион байгуулсугай.

3. Эрдэм шинжилгээний хурлын бэлтгэлийг сайтар хангаж, нутгийн иргэд, орон нутгийн судлаачдыг өргөнөөр оролцуулан үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Даваадорж), Мянгад сумын Засаг дарга(М.Баатар) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

84.00.01.2307
Zah A/463 tum

Аймгийн Засаг даргын 2022 оны
07 дугаар сарын 21 ны Эдийн
А/463 дугаар захирамжийн хэвсгалт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн

ахлагч : Б.Даваадорж

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүдэд: М.Баатар

- Мянгад сумын Засаг дарга

Г.Нямдаваа

- Шинжлэх Ухааны Академийн Газарзүй,
геозкологийн хүрээлэнгийн эрдмийн
зөвлөлийн гишүүн, доктор, профессор,
судалгааны багийн ахлагч

Б.Гантөмөр

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
ахлах мэргэжилтэн

Ж.Батбаяр

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Г.Жавзанхорлоо

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Ч.Улаанхүү

- Мянгад сумын Засаг даргын Тамгын
газрын дарга

Д.Өрнөхдэлгэр

- Ховд их сургуулийн багш, доктор,
профессор

Нарийн бичгийн дарга:

Б.Гантөмөр

- Ховд их сургуулийн захирал, доктор,
профессор

-oOo-